



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Asian Development Bank

Japan
Fund for
Poverty
Reduction

СОРГҮЙ СОГООВОР



Аль ч мал дуртай. Иймээс таримал хадлан, бэлчээрийн зориулалтаар ургуулна. Хавар эрт сэргэж, зун, намар үлэмж хэмжээний ургац бүрдүүлнэ. Арав гаруй жил ургуулж болох эл таримал 2-3 дахь жилээ бүрэн биежнэ. Гантай нөхцөлд өвсний ургац нь 10-12 центнерээс хэтрэхгүй ч усалж, бордоход үүнээс 2.5-3 дахин нэмэгдэнэ.

Соргүй Согоовор (*Bromus inermis*) ургац ихтэй, хоёроос доошгүй удаа хадаж ашиглах боломжтой олон наст үет ургамал.

Үндэс 2 м хүртэл гүнд тархана. Энэ нь зангилаанаасаа үндэс үүсгэх чадвар бүхий үндэслэг найлзуурын хэвшилтэй. Үндэслэг найлзуур хөрсний гадаргуугаас 10-20 см дор байршина.

Иш олон, шулуун, 180 см хүртэл өндөр болно. Навчны хэмжээ урт, дунд зэрэг, нүцгэн, бага зэрэг үсэрхэг, ногоон хааяа хүрэгтэр ягаан.

Залаа том, саглагар. Үр амуу цаг, өргөн юлдэрхүү хэлбэртэй, 6-8 мм урт, 1000 үрийн жин 3-4 г.

Ган, хүйтэнд тэсвэртэй. Усанд автсан газар бага зэрэг байж чадах тул гол усны сав, намагтай газар ургуулна.

Сул хүчиллэг, саармаг орчинд ургах энэ таримал азот, фосфор, калийн хангамж дундаас дээш хөрсөнд ургана. Зундаа хэд хэдэн удаа хадвал 60-70 центнер өвс авах боломжтой. Нугын хөрснөө хорь гаруй жил амьдарч ургадаг ч тарьсан талбайд 8-10 жил байлгана.

Соортуудаас Дединовский 3, Факельный илүү их таригдана. Дангаар нь тарьж ургуулахаас гадна хөрсний үржил шимийг ойролцоо хэмжээгээр шаардах, өсөлт, биежилтийн хурдац, хэнзлэлт, амьдралын үргэлжлэх хугацаа зэргээрээ төсөө бүхий бусад тарималтай хольж үрлэнэ. Ийм таримал бол царгас юм.

Ердийн мөрөөр үрлэхэд 1 га-д 4 сая (12-14 кг), өргөн мөрөөр бол 2 сая (6-7 кг) ширхэг үр хийнэ. Энэ нь тарих үрийн чанар, бусад нөхцөлөөс шалтгаалж, ердийн мөрөөр үрлэхэд 18-20, өргөн мөрөөр бол 9-10 кг хүрч нэмэгдэх боломжтой. (Дэжидмаа, бусад). Согооврын үр гулсалт муутай учраас унах, асгарах чадвараар барагтайхан юм. Иймээс үрлэгээний өмнө

эл чанарыг сайжруулах арга хэмжээ авна. Энэ ажилд хаймар гадаргуу бүхий хүнсний ногооны үр зүлгэх үрээрашиглана.

Малын тэжээлд бол залаалалтын эхээр авна. Хураалт оройтуулахад иш гуурсжиж, уургийн хэмжээ буурах тул эрт хадна.

Үрийн талбайг бүрэн боловсорсноос хойш шууд хураана. Болц муутай учраас согооврын талбайг ангилан хураах нь дээр байдаг. Энэ тохиолдолд хадалтыг үрийн аарцан болцын үеэр эхэлнэ.

Зэрлэг согоовор Хангай, Хөвсгөл, Хэнтий, Хянган, Алтайн зарим хэсэг, Ховд, Дорнод аймгийн нутгаар тааралдана. Энэ нь ойн чөлөө, нуга, нуур, цөөрмийн эрэг, зам харгуй, тариа, ногооны талбай дагаж ургана.

